



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2018 оны 12 сарын 07 өдөр

Дугаар А/510

Улаанбаатар хот

Улсын төсвийн санхүүжилтээр  
суралцуулахыг цуцлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дах хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 446 дугаар тушаал, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны ажлын хэсгийн 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 75 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн "Хүүхэд судлал" үндсэн мэргэшлийн сургалтын нэгдүгээр дамжааны резидент эмч Г.Алтансүвдыг улсын төсвийн санхүүжилтээр суралцуулахыг 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн цуцалсугай.
2. Резидент эмч Г.Алтансүвдыг улсын төсвийн санхүүжилтээр суралцуулахыг цуцалсантай холбогдуулан дараах арга арга хэмжээг авч ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/-д үүрэг болгосугай.
  - 2.1. Улсын төсвийн санхүүжилтээр суралцуулах гурвалсан гэрээг 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн цуцлах;
  - 2.2. Гэрээ цуцалсан талаар Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв /Ш.Энхтөр/, Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газар /Б.Эрдэнэтуяа/, резидент эмч Г.Алтансүвд нарт албан бичгээр тус тус мэдэгдэх.
3. Эрүүл мэндийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлж ажиллах, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны ажлын хэсгийн 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 75 тоот дүгнэлтэд нэр дурдагдсан албан тушаалтанд зохих хариуцлага тооцож, эргэн мэдэгдэхийг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв /Ш.Энхтөр/-д үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Цогтбаатар/-т даалгасугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ

082005